

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР****Санамж:**

1. Зохиолын хэсгийг анхааралтай уншиж, ойлгоорой.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Сонгож авсан үг, өгүүлбэрийг зохиолын хэсгийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. /Даалгавар бүр 2 оноотой/

**“Хоёр хар буурын туурь”**

Тэр хоёрын зодолдоон оройн нар ортол үргэлжилж билээ. Би эхлээд тэр гайхамшигт тулалдааныг үзэж, хөөр бахархлын цээнд хүрч байсан боловч удалгүй зул бөхөх мэт баярын сэтгэл унтарч, харилцан бие биенээ дуустал хөнөөх гэж зорьж байгааг нь үзээд хүйтэн гүрвэл зүрхэн тус газар мөлхөх лугаа адил болж, айдас төрж эхэлсэн юм. Гэвч дайсагналцах гэдэг тэр болоод өөрийн амийг өрөн байж, дайснаа хөнөөхийг зорих байгаль амьдралын гүн учир начир тэр тулалдааны утга тайлал болж байсныг хожим сэнхрэн ойлгохдоо тэр хоёр буурын хэнд нь ч бурууг эс өгсөн.

...Хаврын цагаан хавсарганы ид үеэр хэвтрээсээ арай гэж босож байсан тэр хоёр луу өлөн чонын сүрэг уулгалан довтолжээ. Лавтайяа, арван тав орчим чонотой тэр хоёр буур харгалдан тулалдсан хийгээд хувь заяа тэднийг үхэл амьдралын босгон дээр нэгэн бурантгаар холбон хөтөлж авчирсныг үзэж, өвөлжин дайсагналцсан хоёр адгуус нэгэн хүн шиг үзэлцсэн байв гэнэ. Гэвч харамсалтай нь буурын хурц шүдэнд тасар татуулж, өвдөг тавхай доор нидрүүлсэн долоон чонын дунд хар буурын сэг байхыг тэмээт Агваанбалдан гуай өөрөө үзсэн юм гэдэг. Тэр мэргэн өвөө:

- Юу ч гэх вэ дээ, адгуус гэж ийм байх юм. Миний хоёр буур бие биетэйгээ харгалдаагүй бол арван таван чоныг арван таван хурга шиг л зажлах сан даа хэмээн толгойгоо барин суужээ.

/Д.Маам/

1. Тэр гайхамшигт тулалдааныг үзээд айдас төрсний учир нь юу вэ?
  - A. Тэр хоёрын зодолдоон оройн нар ортол үргэлжилсэн учраас
  - B. Тулалдааныг үзэж, хөөр бахархлын цээнд хүрч байсан учраас
  - C. Харилцан бие биенээ дуустал нь хөнөөх гэж буйг ойлгосон учраас
  - D. Өвөлжин дайсагналцсан хоёр адгуус нэгэн хүн шиг үзэлцсэн учраас
  - E. Дайснаа хөнөөхийг зорих байгаль амьдралын гүн учир начир тэр тулалдааны утга тайлал болж байсныг хожим сэнхрэн ойлгосон учраас
2. Эхийн тодруулсан цогцолбор утгын ямар зүйлчлэлд хамаарах вэ?
  - A. Хүний
  - B. Адгуусны
  - C. Хүний бүтээсэн
  - D. Сэтгэхүйн
  - E. Гараг эрхсийн
3. “Юу ч гэх вэ дээ, адгуус гэж **ийм** байх юм” - онцолсон үг эхийн аль үйл явдалтай **холбогдохгүй** вэ?
  - A. Хөөр бахархлын цээнд хүрч байсан.
  - B. Тэр хоёрын зодолдоон оройн нар ортол үргэлжилж билээ.
  - C. Бие биенээ дуустал хөнөөх гэж зорьж байгаа.
  - D. Буурын хурц шүдэнд тасар татуулж, өвдөг тавхай доор нидрүүлсэн долоон чоно.
  - E. Арван тав орчим чонотой тэр хоёр буур харгалдан тулалдсан.
4. Дээрх эхийн сэдвийг илэрхийлсэн хэлцийг олоорой.
  - A. Эвдрэл хэрүүлээр, эв нягтралаар
  - B. Эвдрэх юманд эзэн үгүй
  - C. Бууран тэмээнд буйл бурантаг хэрэггүй
  - D. Эв ч гэж зэв дээ
  - E. Буураас айсан тайлаг, буханд мөргүүлсэн бяруу
5. Эхийн гол санааг илэрхийлэх тулгуур өгүүлбэрийг олоорой.
  - A. Миний хоёр буур бие биетэйгээ харгалдаагүй бол арван таван чоныг арван таван хурга шиг л зажлах сан даа.
  - B. Долоон чонын дунд хар буурын сэг байхыг тэмээт Агваанбалдан гуай өөрөө үзсэн юм гэдэг.
  - C. Хаврын цагаан хавсарганы ид үеэр хэвтрээсээ арай гэж босож байсан тэр хоёр луу өлөн чонын сүрэг уулгалан довтолжээ.
  - D. Хувь заяа тэднийг үхэл амьдралын босгон дээр нэгэн бурантгаар холбон хөтөлж авчирсан.
  - E. Өвөлжин дайсагналцсан хоёр адгуус нэгэн хүн шиг үзэлцсэн байв гэнэ.
6. Эхийн хэв маягийг зөв тодорхойлсныг олоорой.
  - A. Эргэцүүлэмж
  - B. Хүүрнэмж
  - C. Тайлбарламж
  - D. Тоочимж
  - E. Эргэцүүлэмж, тайлбарламж хосолсон

7. “Би эхлээд тэр гайхамшигт тулалдааныг үзэж, хөөр бахархлын цээнд хүрч байсан” - өгүүлбэрээс гурван бүрэлдэхүүнт цөм бүтцийг олоорой.  
А. Би эхлээд үзнэ. В. Бахархлын цээнд хүрнэ.  
С. Гайхамшигт тулалдааныг үзнэ. D. Би тулалдааныг үзнэ. E. Би хөөрч бахархана.
8. Утгын зүйлчлэл талаас бусдаасаа өвөрмөц өгүүлбэрийг олоорой.  
А. Бие биенээ хөнөөх В. Гүрвэл мөлхөх С. Сэтгэл унтрах  
D. Хэвтрээсээ босох E. Чонын сүрэг довтлох
9. Харамссан өнгө аястай хэсгийг олоорой.  
А. ...тэр хоёр буурын хэнд нь ч бурууг эс өгсөн.  
В. Миний хоёр буур бие биетэйгээ харгалдаагүй бол арван таван чоныг арван таван хурга шиг л захлах сан даа...  
С. Тэр хоёрын зодолдоон оройн нар ортол үргэлжилж билээ.  
D. ...хүйтэн гүрвэл зүрхэн тус газар мөлхөх лугаа адил болж, айдас төрж эхэлсэн юм.  
E. ...долоон чонын дунд хар буурын сэг байхыг тэмээт Агваанбалдан гуай өөрөө үзсэн.
10. “Тэр хоёр буурын хэнд нь ч бурууг эс өгсөн” - өгүүлбэрийн өгүүлэхүүнийг захирах төлөвт хувиргасныг сонгоорой.  
А. өг В. өгсөн үү С. өгсөн дөө D. өгсөн юм E. өгөв
11. “Долоон чонын дунд хар буурын сэг байхыг тэмээт Агваанбалдан гуай өөрөө үзсэн юм гэдэг” - өгүүлбэрийг салаалан хувиргасан нь аль вэ?  
А. Хар буурын сэг долоон чонын дунд байхыг тэмээт Агваанбалдан гуай өөрөө үзсэн юм гэдэг.  
В. Долоон чонын дунд хар буурынх нь сэг байсныг тэмээт Агваанбалдан гуай өөрөө харсан юм гэнэ лээ.  
С. Долоон чонын дунд хар буурын сэг байхыг Агваанбалдан гуай үзсэн юм гэдэг.  
D. Долоон чонын дунд хар буурын сэг байхыг тэмээт Агваанбалдан гуай өөрөө үзээд харуусан ярьсан гэдэг.  
E. Долоон чонын дунд хар буурын сэг байхыг тэмээт Агваанбалдан гуай өөрөө үзсэн юм гэдэг.
12. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.  
А. Өвгөний юу бодож, юу хүсэж, юунд зовниж буйг хэн ч үл мэднэ.  
В. Хоймрын авдар дээр хөгшний бадраасан зул гал дохиуртай хар цэцэг мэт бадамлан бөхөж байна.  
С. Хаврын буурал талд урины зэрэглээ буужээ.  
D. Тэнгэрийн хураар тэжээгдсэн түмэн жилийн үндэст хээр талын цэцэг ногоо мэт дэлгэрэх болтугай.  
E. Хувцсаа дасгах журмаар нимгэлэх ба биеийн тамирын дасгал хөдөлгөөнт тоглоомыг хийхэд чөлөөтэй хөдөлж байхуйц хувцсыг хэрэглэнэ.
13. “Арван таван чоныг арван таван хурга шиг л захлах сан даа” - өгүүлбэрт чоно, хургыг эсрэгцүүлсэн нь аль хэлцээс үүдэлтэй вэ?  
А. Чоно махнаас гарах В. Чонын санаа гаргах С. Хонь шиг номхон  
D. Хонины морь шиг E. Чоно нь хонио
14. “Харилцан бие биенээ дуустал хөнөөх гэж зорьж байгааг нь үзээд хүйтэн гүрвэл зүрхэн тус газар мөлхөх лугаа адил болж, айдас төрж эхэлсэн юм” - өгүүлбэрээс шууд тусагдахуун гишүүнийг олоорой.  
А. бие биенээ В. хөнөөх гэж С. зорьж байгааг нь D. зүрхэн тус газар E. айдас
15. “Хүйтэн гүрвэл зүрхэн тус газар мөлхөх лугаа адил болж, айдас төрж эхэлсэн юм” - гэдэгтэй ойролцоо санаат өгүүлбэрийг олоорой.  
А. Зүрх амаар гарам түгшин, хөл гар бүр чичирхийлэн байлаа.  
В. Түүнийг харахлаар л зүрх булгаалаад... би дурлажээ.  
С. Чулууны зүрхийг маажин догдлуулахад даруй сэтгэл нь тогтож ядан гадаа гарав.  
D. Богдын бүлтийн харсан хүйтэн харцыг зүрх гарган өөдөөс нь ширтлээ.  
E. Энэ цэргийн хар угаасаа зүрхний хийтэй нөхөр юм билээ.

16. "...өвөлжин дайсагналцсан хоёр адгуус нэгэн хүн шиг үзэлцсэн байв гэнэ" – хэсэгт дүрсэлсэн хоёр хар буурын зан байдалтай тохирохыг олоорой.
- A. Эвдрэх нэг өдөр байхад эвлэрэх нэг өдөр байна
  - B. Эвдэрвэл эрхий хомхой хоёр ч нийлэхгүй.
  - C. Үхсэн буурын толгойноос амьд ат айна
  - D. Давах даваанд дайсан учирдаг
  - E. Тэмээ хариулсан хүн буурынхаа занг андахгүй
17. "Өвдөг тавхай доор нидрүүлсэн долоон чонын дунд хар буурын сэг байжээ" - өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой.
- A. Нэрийн хамжсан тодотгол гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
  - B. Үйлийн хамжсан тодотгол гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
  - C. Цагийн байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
  - D. Холимог нийлмэл өгүүлбэр
  - E. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
18. "Хаврын цагаан хавсарганы ид үеэр хэвтрээсээ **босож байсан** тэр хоёр луу өлөн чонын сүрэг довтолжээ" - онцолсон өгүүлэхүүнийг яаж хувиргавал цагийн байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр болох вэ?
- A. босоод
  - B. босмогц
  - C. босон
  - D. босдог байсан
  - E. босмоор байдаг
19. "Хүйтэн гүрвэл зүрхэн тус газар мөлхөх лугаа адил болж, айдас төрж эхэлсэн юм" гэсэн хэсэгт айж буйг зүрхэнд гүрвэл мөлхөхтэй зүйрлэн дүрсэлсэн нь хэр оновчтой вэ?
- A. Монголчууд зоригийг зүрхтэй холбон тайлбарладаг боловч хүйтэн цуст амьтан зүрхнээ мөлхөнө хэмээн дүрсэлдэг уламжлал үгүй учир оновчгүй байна.
  - B. Хүн бүхэн хүйтэн цуст гүрвэлээс айдаггүй учир ингэж дүрслэх шаардлагагүй.
  - C. Гүрвэлийг зүрх биш тархинд мөлхөж буйгаар дүрсэлсэн бол оновчтой болох байж.
  - D. Монголчууд айдсыг зүрхтэй холбон тайлбарладаг бөгөөд хүйтэн цуст амьтан зүрхнээ мөлхөнө хэмээсэн нь айж буйг илэрхийлсэн зөв дүрслэл болжээ.
  - E. Гүрвэлд хамаагүй халдвал хараадаг гэдэг уламжлалтай бөгөөд энэ ч утгаараа айдастай холбон дүрсэлсэн нь оновчтой болсон.
20. Ерийн, үүсмэл, ганц тоот, гарахын тийн ялгал, эзэнд /ерөнхийлөн/ хамаатуулах нөхцөлтэй жинхэнэ нэрийг олоорой.
- A. толгойгоо
  - B. биетэйгээ
  - C. тулалдааны
  - D. хэвтрээсээ
  - E. дайснаа
21. Бүгд гурван үе бүхий бүлэг үгийг олоорой.
- A. зодолдоон, хоёрын, үргэлжилж, бахархлын, тулалдааныг
  - B. харилцан, өвөлжин, эхэлсэн, амьдралын, нидрүүлсэн
  - C. авчирсныг, биенээ, дайсагналцах, довтолжээ, үзэлцсэн
  - D. хэвтрээсээ, толгойгоо, харгалдан, хавсарганы, бурантгаар
  - E. ойлгохдоо, уулгалан, харамсалтай, тулалдсан, харгалдаагүй
22. "Тэр хоёрын зодолдоон оройн **нар ортол** үргэлжилж билээ" - тодруулсан хэсгийг солин найруулбал аль нь тохиромжтой вэ?
- A. нар жаргатал
  - B. нар ургатал
  - C. нар голлотол
  - D. нар хошилтол
  - E. нар дэгжтэл
23. "**Лавтайяа**, арван тав орчим чонотой тэр хоёр буур харгалдан тулалдсан" - онцолсон баймжтай утга ойролцоо үгийг олоорой.
- A. Нэг үгээр хэлбэл
  - B. Бараг
  - C. Санаандгүй
  - D. Мэдээжээр
  - E. Минийхээр бол
24. "...**Гэвч** харамсалтай нь буурын хурц шүдэнд тасар татуулж, өвдөг тавхай доор нидрүүлсэн долоон чонын дунд хар буурын сэг байхыг тэмээт Агваанбалдан гуай өөрөө үзсэн юм гэдэг" - тодруулсан холбоосыг тохирох үгээр солин найруулаарай.
- A. Тэр үед
  - B. Мөн
  - C. Гэсэн ч
  - D. Бас
  - E. Түүнчлэн
25. Эхийн өгүүлбэрүүдээс найруулгын доод зэрэгт хувиргасныг олоорой.
- A. Хэвтрээсээ арай гэж өндийж байсан.
  - B. Зул унтрах мэт
  - C. Өлөн чонын сүрэг уулгалан дайрчээ.
  - D. Өрсөлдөгчөө хөнөөхийг зорих.
  - E. Тэр хоёр буур харгалдан тэмцсэн.

26. “Тэр хоёрын зодолдоон оройн нар ортол үргэлжилж билээ” - өгүүлбэрт **ороогүй** үгийн аймгийг олоорой.  
 А. Тооны нэр      В. Жинхэнэ нэр      С. Үйл үг      D. Орон цагийн нэр      E. Тэмдэг нэр
27. Чөлөөт бус холбоо үгсийн зүй тогтлыг ажиглаад цэгийн оронд тохирохыг нөхөөрэй.  
 Хүрч байсан, тэр хоёр, төрж эхэл, тэр тулалдаан, бие биенээ, нэгэн бурантаг, .....  
 А. хөөр бахархал      В. босгон дээр      С. хувь заяа      D. хүйтэн гүрвэл      E. учир начир
28. “Чиний наадах **бөндгөрт** чинь ухааны цурам байна уу? Үгүй юу?”,  
 “Ёнхор өвөө гэгч **тэргүүн** буурал ч ухаан саруул” – өгүүлбэрүүдэд толгой хэмээх үгийг найруулгын зэргээр хувирган бичсэнийг хэрхэн дүгнэх вэ?  
 А. Үгийн өнгө аяс, өгүүлэгчийн сэтгэл хөдлөлийг бүрэн илэрхийлэхэд дөхөмтэй учир найруулгын зэргээр бичсэн нь оновчтой.  
 В. Зарим үгсийн найруулгын доод зэргийг хүмүүс мэдэхгүй учир ингэж бичих нь тохиромжгүй.  
 С. Зөвхөн сонин нийтлэлийн найруулгад хэрэглэдэг тул найруулгын алдаа болно.  
 D. Доромж утгатай үгсээр утга шилжүүлэн дүрслэх нь тохиромжгүй.  
 E. Судар номын эрхэмсэг дээд найруулгыг зарим хүн ойлгохгүй тул дунд найруулгаар бичих нь зөв.
29. “амьдралынхаа” гэдэг үгийн үйлээс нэр үг бүтээх дагаврыг олоорой.  
 А. –д      В. –р      С. –л      D. –дар      E. –рал
30. Эхээс сонгосон үгсээс бүтцээр нь зөв задалсныг олоорой.  
 А. үргэлж+л+0+0+ж      В. бие+тэй+гээ      С. үз+л+ц+н  
 D. дайсан+гна+лц+сан      E. эх+лэ+0+0+сэн
31. Нэг юмыг нөгөөгөөс салган авах утгыг үүсгэсэн “-л” дагавартай бүлэг үгийг олоорой.  
 А. Чөдөрлөх, хазаарлах, ногтлох, богочлох  
 В. Савлах, уутлах, авдарлах, хайрцаглах  
 С. Хургалах, ишиглэх, унагалах, тугаллах  
 D. Зогдорлох, дэллэх, хөөвөрлөх, ноослох  
 E. Шиллэх, дээвэрлэх, чимэглэх, бүслэх
32. “Усч өвгөн “ганцхан алдаар зөрүүлчихэж” гэж үглэсээр уснаас гарч ирээд амьсгаадаж туйлдсанаа сая мэдэрч...” – өгүүлбэрээс алдаатай бичсэн нэг үгийг зөв болгон зассаныг олоорой.  
 А. зөрүүлчхэж      В. үглэсээр      С. усанаа      D. туйлдаснаа      E. мэдэрж
33. Бусдын эрхэнд үйлдэгдэх хэвийн дагаврыг **найруулгын алдаатай** хэрэглэсэн жишээг олоорой.  
 А. Ингэн тэмээний гэгэлгэн буйлах дуу нэгэн үе сонсогдож, нэгэн үе замхарна.  
 В. Би аргалчин ээжийн хормойноос зүүгдэн өссөн талын хүн.  
 С. Хоёр хун хөвсөөр арлын зүүн тохойд ороод үзэгдэхгүй болов.  
 D. Жараад оны дуунууд миний тоглолтод дуулагдана.  
 E. Сайхан сэтгэл гэгч харанхуйд ч харагдах өнгөтэй байдаг.
34. “Цээлхэн дуугаар хариулав” - онцолсон баймж бүтээврийн утгатай хамгийн ойр хэсэг аль нь вэ?  
 А. Чинийх долоо, минийх долоо**хон**  
 В. Дотроо бодолтой**хон** шиг явах хэрэгтэй.  
 С. Үс гээгээ хором**хон** зуур янзалж амжжээ.  
 D. Цагаа буцалгах гэсээр удчихлаа. Чи их хүлээв үү? гээд зайдуу**хан** суув.  
 E. Хийлийн алтан утас шиг уя**хан** эгшиг сонсов.
35. Утга төгс өгүүлбэр бүтээхэд цэгийн оронд аль бүтээврүүд дарааллаараа тохирох вэ?  
 “Хөндий тал... зэрэглээ мяралз... жирэлзэх нь хол... үзэх... сонин”  
 А. –ын, -н, -оос, -д      В. –ын, -н, -ын, -д      С. –аас, -ж, -оос, -ийг  
 D. –д, -аад, -оос, -ийн      E. –д, -даг, -ыг, -ээр

36. Зөв бичсэн хэсгийг олоорой.

- |  |   |   |   |  |
|--|---|---|---|--|
| A  | B   | C   | D   | E  |
| ٧مکن ٧نکمر ٧م<br>٧مصرهن ٧و<br>٧سن ٧خپړه ٧مکمر<br>٧مستکړبا ٧و | ٧مکن ٧نکمر ٧<br>٧مصرهن ٧و<br>٧سن ٧خپړه ٧مکمر<br>٧مستکړبا ٧و | ٧مکن ٧نکمر ٧<br>٧مصرهن ٧و<br>٧سن ٧خپړه ٧مکمر<br>٧مستکړبا ٧و | ٧مکن ٧نکمر ٧<br>٧مصرهن ٧و<br>٧سن ٧خپړه ٧مکمر<br>٧مستکړبا ٧و | ٧مکن ٧نکمر ٧م<br>٧مصرهن ٧و<br>٧سن ٧خپړه ٧مکمر<br>٧مستکړبا ٧و |

37. Цэгийн оронд цагт нэрийн тохирох дагаврыг дарааллаар нь нөхөж, зүйр цэцэн үг бүтээгээрэй.

- |   |   |  |   |   |   |
|---|---|--|---|---|---|
| ٧سوق ... ٧سوق ٧تن ٧م<br>٧ميرب ...<br>٧معدا ... ٧سوق ٧تن ٧م<br>٧مشتو ... | A   | B  | C   | D   | E   |
|   | - ٧سوق -<br>- ٧ميرب -<br>. ٧معدا - ٧سوق ٧م<br>٧مشتو - ٧ميرب | - ٧ميرب -<br>- ٧معدا -<br>. ٧معدا - ٧سوق ٧م<br>. ٧ميرب - ٧معدا | - ٧سوق -<br>- ٧ميرب -<br>. ٧معدا - ٧سوق ٧م<br>. ٧ميرب - ٧معدا | - ٧سوق -<br>- ٧ميرب -<br>. ٧معدا - ٧سوق ٧م<br>. ٧ميرب - ٧معدا | - ٧سوق -<br>- ٧ميرب -<br>. ٧معدا - ٧سوق ٧م<br>. ٧ميرب - ٧معدا |

38. “Монголын нууц товчоо” зохиолд Чингис хаан:

“...Намайг залуу байхад  
 Найман шаргыг эрэх үед  
 Наран ургах хэрд  
 Надтай уулзсанаас хойш  
 Насад үнэнээр зүтгэсэн...” хэмээн хэнийг магтан өгүүлдэг вэ?

- A. Зэв                      B. Боорчи                      C. Борохул                      D. Жамуха                      E. Зэлмэ

39. “Монголын нууц товчоо” зохиолын:

“Хавиргаа хазах  
 Хар нохой мэт  
 Хаданд довтлох  
 Харцага шонхор мэт” - хэсэгт ямар дүрслэх хэрэглүүр илэрч байна вэ?

- A. Амьдчилал                      B. Тойруулал                      C. Ихэсгэсэн зүйрлэл  
 D. Ёгтлол                      E. Төлөөлөл

40. Дараах зохиолуудын хэсгийг нэртэй нь харгалзуулаарай.

- |   |  |
|---|--|
| 1. Арслан барс хоёр ноцолдож байгаа ч юм шиг<br>Ачаатай цагаан тэмээ хэвтэж байгаа ч юм шиг                 | a. Д.Намсрай “Жамухын өчил”<br>өгүүллэг                |
| 2. Тэнгэрт хос наран мандвал газарт ган болж гал шатна.<br>Монголд хоёр хаан байвал дажин самуун тасрахгүй. | b. Д.Мягмар “Үер” тууж                                 |
| 3. “Муу зөнөг толгой чи ус нэмэхийг ч үзэх гэж ирээгүй<br>байх аа” гэж Дориг бодно.                         | c. Д.Нацагдорж “Учиртай гурван<br>толгой” жүжиг        |
| 4. Ухаа хонгор морьтой<br>Улсын их жанжин даа   | d. Ц.Дамдинсүрэн “Зугаацахаар<br>мордсон нь” найраглал |
| 5. Нийлсэн хоёр сэтгэл нь<br>Мянган лангийн үнэтэй  | e. “Шивээ хиагт” дууны шүлэг                           |

- A. 1d2a3b4c5e                      B. 1c2a3d4e5b                      C. 1a2d3b4e5c  
 D. 1b2d3a4e5c                      E. 1d2a3b4e5c

## ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

### Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1 Аман зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай.

- |   |                      |
|---|----------------------|
| a. Ороо хар дороо бусгана<br>Жороо бор жолоо дугтарна               | 1.Цэцэн үг           |
| b. Өглөөний нар шиг мандаж яв<br>Өндөр хангайн цэцэг шиг дэлгэрч яв | 2. Онъсого           |
| c. Оёхгүй байж зүүтэй<br>Өнхрөхгүй байж бөөрөнхий                   | 3. Магтаал           |
| d. Өвөр дээрээ өвөлжөөтэй<br>Өвлийн гурван сар нь өнтэй             | 4. Ерөөл             |
| e. Ойроос эхэлбэл хүрнэ<br>Холоос эхэлбэл эцнэ                      | 5. Хэл зүгшрүүлэх үг |

2.2 “Хоёр хар буурын туурь” зохиолын хэсгээс авсан дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулаарай.

- |              |  |
|--------------|--|
| a. Хавсарга  | 1. Тэмээний буйлнаас уяж хөтлөх нарийн оосор |
| b. Харгалдах | 2. Цохих дэлсэх                              |
| c. Бурантаг  | 3. Хуурай, хүйтэн салхи шуурга               |
| d. Нидрэх    | 4. Нас гүйцсэн агтлаагүй эр тэмээ            |
| e. Буур      | 5. Харшилдах, тэмцэлдэх                      |

2.3 Зөвийг нь олж харгалзуулаарай.

		1	2	3	4	5
a	Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг үүрэггүй болж гээгдэх үг	бамбар+ аас	таслал+ аас	үзвэр+ ээс	өглөг+ өөс	түүвэр+ ээс
b	Үйлийн зэрэгцэх тийн ялгалын “-ж” нөхцөл залгах үг	нис-	ав-	хүр-	сур-	хөөр-
c	Зөөлний тэмдэг “и” болох үг	тарь+ц	хорь+г	холь+дог	уугь+ж	амь+тай
d	Эр үгэнд “-ий” бичих үг	хурга	тараг	дарга	унага	ботго
e	Цагаар төгсгөх /үйлийн ерөнхийлөн хамаатуулах/ “-на <sup>4</sup> ” нөхцөлийг шууд залган бичих үг	мөлх+нө	урс+на	орш+но	хийс+нэ	холд+но

2.4 Хэрэглээний бичвэрийг жишээтэй нь харгалзуулаарай.

- |   |                        |
|---|------------------------|
| a. М.Мандухай нь сурах арга барил сайн эзэмшсэн.  | 1. Өргөдөл             |
| b. Миний эцгийн эцэг Х.Түмэнжаргал одоогийн Завхан аймгийн Түдэвтэй сумын нутаг, Ойгон нуурын хөвөөнд төрсөн.                     | 2. Захидал             |
| c. Иймд Т.Бат миний биеийг ажлаас чөлөөлж өгнө үү?  | 3. Тодорхойлолт        |
| d. Ван эрхэм То-ийн амгаланг эрмой.   | 4. Зарлиг              |
| e. “Монголын нууц товчоо”-г айл өрх бүр өргөө гэрийнхээ хойморт залж, сүслэн дээдэлж байхыг Монголын нийт ард иргэдэд зөвлөсүгэй. | 5. Гурван үеийн намтар |

